

ГАН ХИЙЦ ХК ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

**1. Компаний нэр, оршин байгаа хаяг:**

Хаяг: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг 7-р хороо баянхошуу

Утас : 70182448, 70172467

Факс: 70182448, 70172467

Электоран хаяг:

[www.gankhiits.mn](http://www.gankhiits.mn)

**2. Үнэц цаас гаргагчийн мэдээлэл, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл**

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах замаар ашигтай ажиллах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

Компани нь дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.

- Барилгын даацын болон даацын бус бүх төрлийн төмөр хийцийг үйлдвэрлэх
- Барилгын засал чимэглэл, барилга угсралтын ажил гүйцэтгэх

**3. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзэлж буй байр суурь**

Ган хийц ХКомпани нь 1985 онд жилдээ 6000 тн төрөл бүрийн төмөр хийц эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтайгаар “**Барилгын Материалын Үйлдвэрийн Яам**”-ны харъяа Барилгын Төмөр Хийцийн Үйлдвэр нэртэйгээр анх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1992 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн УБ хот ардын хурлын гүйцэтгэх захиргааны өмч хувьчлалын комиссын 121 дүгээр тогтоолоор Үйлдвэрлэл Худалдааны “Ган хийц”төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд 242464 ширхэг хувьцаа гаргаж, төрийн өмчид 51% буюу 123657 ширхэг хувьцаа үлдээж, үлдсэн хувьцааг зах зээлд арилжаалж байсан.

2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн тархалтын судалгаагаар 122 хувьцаа эзэмшигч, 29 брокерийн компани дээр байрлаж байна.

Манай компани нь үүсгэн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр тогтоосон хугацаанд зарлан хуралдуулж, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нөхцөл, журам, шаардлагын дагуу хэрэгжүүлж хэвшүүлж ирсэн ба хувьцаа эзэмшигчдэд 1993-2014 онуудад тодорхой хэмжээний ногдол ашиг хувиарласаар ирсэн.



**5. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл**

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс		
		Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил, боловсрол
1	М.Даваасүрэн	ТУЗ-ийн дарга	Барилгын инженер
2	З.Батхаан	ТУЗ-ийн гишүүн	Механик инженер
3	Б.Эрдэнэбаяр	ТУЗ-ийн гишүүн	Барилгын инженер
4	Ц.Пүрэвжаргал	ТУЗ-ийн гишүүн	Барилгын инженер
5	Б.Ганбат	ТУЗ-ийн гишүүн	Механик инженер
6	Э.Долгорсүрэн	ТУЗ-ийн гишүүн	Нягтлан бодогч
7	П.Төвсанаа	ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн	Эдийн засагч
8	Р.Эрдэнэцогт	ТУЗ-ийн гишүүн Хараат бус гишүүн	Дулааны инженер
9	Д.Энхбаатар	ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн	Төрийн удирдлага
10	О.Ууганцэцэг	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Хүний нөөцийн менежер

**Хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчийн мэдээлэл**

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Эзлэх хувь
М.Даваасүрэн	173580	71,59
Хасвуу ХХК	44263	18,25

## **6. Хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ**

Компанийн санхүүгийн тайланг Баян ташаагийн эх ХХК аудит хийлгэж байгаа бөгөөд 2014 оны 8 дугаар сард Санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос анхан шатны бүртгэл, үйл ажиллагаанд нь шалгалт хийж дүгнэлт гаргасан бөгөөд 2015 онд Санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах тогтоол шийдвэр, удирдамж гаргаж, бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт оруулан ажиллаж байна.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, төлбөр тооцоог цаг тухайд нь хийж байна.

Компани 2015 оны 2-р улирлын байдлаар 304 841 546.53 төгрөгийн борлуулалтын орлоготой, 112 463 135.64 төгрөгийн алдагдалтай байна.

2014 оноос эхлэн санхүүгийн хямрал тулгарч ажлын захиалга багасч, дотоодын санхүүжилт бууран авлагын барагдуулалт муу байгаа нь алдагдалтай ажилласны гол шалтгаан болж байна.

**Улаанбаатар аймаг /хот/-ын СХД-ийн  
Ган хийц ХК-ийн санхүү , аж ахуйн үйл ажиллагааны 2015 оны  
жилийн тайлан тэнцлийн хураангуй үзүүлэлт дараахь байдалтай байгааг  
мэдээлж байна**

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	Мөрийн дугаар	Тайлант жилийн дүн	
		Аудитлагдсан	
<b>2.Орлого үр дүнгийн тайлан</b>			
		<b>2014.12.31</b>	<b>2015.06.30</b>
Борлуулалтын орлого	39	2,348,467.9	304,841.5
Борлуулсан бүтээгдхүүний өртөг	41	1,790,808.3	180,659.3
<b>Нийт ашиг</b>	<b>42</b>	<b>557,659.6</b>	<b>124,182.2</b>
Удирдлага борлуулалтын зардал	43	549,248.5	225,315.2
<b>Үйл ажилгааны ашиг /алдагдал</b>	<b>44</b>	<b>8,411.1</b>	<b>(101,133.0)</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	46	84,132.0	416.0
Үндсэн бус үйл ажиллагааны зарлага	47	43,209.4	11,788.3
Валютын ханшийн зөрүүний олз(гарз)		357.8	42.1
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/ алдагдал</b>		<b>41,280.4</b>	<b>(11,330.2)</b>
<b>Татварын өмнөх ашиг /алдагдал</b>	<b>48</b>	<b>49,691.5</b>	<b>(112,463.2)</b>
Орлогын албан татвар	49	9,290.10	-
<b>Цэвэр ашиг/ алдагдал</b>	<b>50</b>	<b>40,401.4</b>	<b>(112,463.2)</b>
<b>3.Өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
<b>Өмчийн эхний үлдэгдэл</b>	<b>51</b>	<b>1,558,403.8</b>	<b>936,548.3</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй ашиг/алдагдал	52	(604,016.7)	
Тайлант үеийн ашиг/ алдагдал	53	40,401.4	(112,463.2)
Ногдол ашиг	54	58,240.2	
<b>Өмчийн эцсийн үлдэгдэл</b>	<b>56</b>	<b>936,548.3</b>	<b>824,085.1</b>
<b>4.Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,272,374.3</b>	<b>54,447.7</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		1,217,926.5	(43,516.8)
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>54,447.8</b>	<b>10,930.9</b>

## **7. Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн орсон өөрчлөлт**

2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Гүйцэтгэх захирлын томилох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захиралд Раднаа овогтой Эрдэнэцогтыг томилж, гэрээ байгуулан ажиллаж байна.

## **8. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр**

Төлөөлөн Удирдах зөвлөл Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цаг хугацаанд нь шаардлагын дагуу зарлан хуралдуулдаг бөгөөд 2015 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэсэн :

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 14 ны өдөр Компаний байранд хуралдуулахаар шийдвэрлэсэн.
- 2014 оны Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хувиарлахаар шийдвэрлэсэн
- Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан З.Батхааны ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Л.Чинбат, А.Эрдэнэ, Хасвуу ХХК, С.Мягмарсүрэн нар 90,57% /219606 ширхэг/-ийн ирцтэйгээр хуралд оролцов. Хурлаар 2014 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэсэн ажлын тайлан, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв, Компанийн үйл ажиллагааны зардлыг төсвийг хэлэлцэж дараах дүгнэлтийг гаргасан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлыг хангалттай гэж дүгнэв,
2. 2015 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 134847840 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2015 оны төсвийг 677853640 төгрөгөөр батлаж Гүйцэтгэх захиралд үүрэг өгч ажиллаж байна.

2014 онд цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг 100 төгрөгөөр тогтоож, 242464 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 122 хувьцаа эзэмшигчдэд 24246400 төгрөгийн ногдол ашиг хувиарлахаар батласан. 2015 оны 07 дугаар сард Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан 100 хувьцаа эзэмшигчийн 13654 ширхэг хувьцаанд ногдох 1228860 төгрөгийг шилжүүлэн, дансанд нь байршуулан ажиллаж байна. 22 хувьцаа эзэмшигчийн 228810 ширхэг хувьцаанд ногдох ашгийг компани дээрээс тараахаар шийдвэрлэсэн.